

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОЧ

Я.САМБУУНЯМ

УНДНЫ УС, АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖТАЙ ХОЛБООТОЙ ХЭРЭГЖҮҮЛЖ
БҮЙ ТӨСӨЛ ХӨТӨЛБӨРҮҮД, ТЭДГЭЭРИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЖ, ДҮГНЭЛТ
ГАРГАХ ЗӨВЛӨХ ШИНЖЭЭЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 4 дүгээр ... сарын
8.-ний /ны/ өдөр

Дугаар УАГ-АД/2025-В Улаанбаатар хот

Ажлын зорилго

“Ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар ТХЗ 6 дугаарт “Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах” зорилгын хүрээнд Монгол Улсын хүн амын ундны усны нөөц, усны чанар, халдвартгүйжүүлэлт, ус ашиглалтын болон ариун цэврийн байгууламжийн өнөөгийн нөхцөл, цаашид аюулгүй, баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийн төлөв байдлын судалгаа хийж, хэрэгжүүлж буй дотоодын болон олон улсын төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөөг тооцож, хэрэгжилтийг үнэлэх, мэргэжлийн санал, зөвлөмж, дүгнэлт гаргахад энэхүү ажлын зорилго оршино.

Эхлэх хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдөр

Дуусах хугацаа: 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Байршил: Засгийн газрын 4 дүгээр байр

Нэг. ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны 2024 оны “Аудитын сэдэв батлах тухай” 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын “Төрийн аудитын байгууллагын 2025 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө” 2024 оны А/108 дугаар тушаалыг тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгын ТХЗ-6 “Хүн бүрд ус, ариун цэврийн байгууламжийг хүртээмжтэй хүргэж, тэдгээрийн тогтвортой менежментийг хангах”, 6.1 “2030 он гэхэд хүн бүрийг ундны аюулгүй, боломжийн үнэтэй усаар хангах”, 6.2 “2030 он гэхэд хүн бүрийг тэгш хүртээмжтэй, эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн байгууламжид хамруулж, охид, эмэгтэйчүүд, эмзэг бүлгийнхний хэрэгцээ шаардлагыг онцгойлон анхааран үзэж ил задгай биээ засах явдлыг зогсоох” зорилгын хүрсэн түвшинг тодорхойлох, хүн амын аюулгүй ундны усны хангамж, цэвэрлэх байгууламжийн хамрагдалтыг сайжруулахад төрөөс баримталж байгаа урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд, тэдгээрийн хэрэгжилт, зохицуулж буй хууль эрх зүйн актуудын үйлчлэх

хүрээ, уялдаа холбоо, цаашид анхаарах, сайжруулах асуудлыг тодорхойлох, хүн амын аюулгүй ундны усны хангамж, цэвэрлэх байгууламжийн талаар мэргэжлийн дүгнэлт зөвлөмж гаргах, аудитын багт үнэлгээ хийх арга зүйн зөвлөмж өгөх шинжээчийн туслалцаа шаардлагатай тул Төрийн аудитын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3 дахь, МУЕА-ын 2020 оны А/82 дугаар тушаалаар баталсан “Шинжээч сонгон шалгаруулах, гэрээ, байгуулах, дүгнэх, гүйцэтгэсэн ажлын чанарыг хянах журам”-ыг үндэслэн мэдлэг, ур чадвар бүхий этгээдийг шинжээчээр татан оролцуулах шаардлага үүссэн.

Хоёр. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Ажлын зорилтыг хүрээнд хүн амын аюулгүй ундны усны хангамж, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хамааралтай Монгол Улсын Засгийн газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Эрүүл мэндийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Үндэсний статистикийн хороо, Усны газар, орон нутгийн ус хангамж, цэвэрлэх байгууламжийн асуудал хариуцсан этгээдүүд, бусад холбогдох байгууллагуудыг хамруулна.

ҮАГ-ын аудитын баг болон шинжээчийн баг ундны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй бодлогын үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрүүдийн төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэлтэй холбоотой шаардлагатай баримт, материалыг дээрх байгууллагуудаас гаргуулан авна. Шинжээчийн баг бэлтгэгдсэн ажлын баримт материал, баримтат нотлох зүйлсэд үндэслэн төслийн байршил дээр үзлэг шалгалт хийх, ажлын тоо хэмжээг тулгах, дүн шинжилгээ, тооцоолол хийнэ.

Гурав. ГҮЙЦЭТГЭХ АЖИЛ

Шинжээч нь дараах ажилбаруудыг гүйцэтгэж, аудитын талбарын болон тайлاغналын үе шатанд аудитын багийг мэргэжил, арга зүйгээр хангана. Үнд:

№	Гүйцэтгэх ажил, үүрэг	Үндэслэл	Зорилго	Шалгуур үзүүлэлт
1	Хүн амыг ундны аюулгүй, хүртээмжтэй усаар хангах, эрх зүйн орчин, бодлогын баримт бичгүүдийн уялдаа холбоонд судалгаа хийн боловсруулж аудитын багт арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн дүгнэлт гаргах.	Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хууль эрх зүйн актуудад хүн амын ундны ус, түүний аюулгүй, хүртээмжтэй байдлыг тусгасан заалтууд, НҮБ-ын ТХЗ 6.1, 6.2-ын заалтууд	Монгол Улсын хүн амыг аюулгүй ундны усаар, хүртээмжтэй, боломжийн үнээр хангах талаар баримталж буй бодлого, хууль тогтоомж, журам, бусад хэм хэмжээ нь иж бүрэн зохицуулалт хийх боломжийг бүрдүүлж байгаа эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлыг зорилго оршино, Аудитын багийн гишүүдэд мэргэжлийн	<ul style="list-style-type: none"> “Алсын хараа-2050” монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа; Усны тухай хууль; Эрүүл ахуйн тухай хууль; Байгаль орчны тухай хууль; ЗГ-ын 2013 оны 326-р тогтоол усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ;

			зөвлөгөө өгөх,	
2	Нийслэл, орон нутагт хүн амьг унд, ахуйн усны нөөц, хэрэглээг тооцож хянадаг, аюулгүй байдал, боломжийн үнээр хангах, тогтоогдсон усны ордын ашиглалт, цаашид хэдэн жилийн хэрэглээний нөөцтэй талаар тооцоолол, дүн шинжилгээ хийдэг олон улсын жишээ, монгол улсын нөхцөл байдлыг харьцуулсан судалгаа хийх	Монгол Улсын хүн амьын ундны усны нөөц, усны чанар, халдвартгүйжүүлэлт, ус ашиглалтын судалгаа хийж, олон улсын жишигтэй харьцуулан мэргэжлийн санал, зөвлөмж, дүгнэлт гаргах.	Монгол Улсын хууль, журмын дагуу хүн амьын ундны унд, ахуйн усны нөөц, хэрэглээг тооцож хянадаг, тогтоогдсон усны ордын ашиглалт, цаашид хэдэн жилийн хэрэглээний нөөцтэй талаар тооцоолол хийсэн эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлыг зорилго оршино, Аудитын багийн гишүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх,	Усны тухай хуулийн 4.4.Энэ хуулийн 21.1-д заасан мэргэжлийн байгууллага нь усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг хайгуул, судалгаагаар тогтооно. 4.5.Усны нийт нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг усны нөөцийн зөвлөл батална. 7.1.Улсын усны мэдээллийн сан нь гадаргын болон газрын доорх ус, рашааны төлөв байдал, орон зайн үзүүлэлт, усны нөөцийн нийт болон ашиглах боломжит хэмжээ, чанар, өөрчлөлт, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалт, хаягдал ус зайлвулахтай холбогдсон мэдээ, экологи-эдийн засгийн үнэлгээ, ус хэрэглэгч, ашиглагчийн тухай мэдээлэл, хайгуул, судалгааны тайлан, усны барилга байгууламж ийн байршил, хүчин чадал, техникийн үзүүлэлт зэрэг мэдээллээс бүрдэнэ.
3	Үндны усанд хийсэн хяналт шинжилгээгээр эерэг сорьцтой гарсан химийн элементүүдийг хэрхэн бууруулах, хүний биед хэрхэн нөлөөлдөг, эрсдэлийг тооцдог талаар судалгаа, шинжилгээ хийж боловсруулан мэргэжлийн дүгнэлт гаргах.	Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ байнгын ажиллагаатай байгаа талаар, Үндны усанд хийсэн хяналт шинжилгээгээр эерэг сорьцтой гарсан химийн элементүүдийг хэрхэн бууруулах, хүний биед хэрхэн нөлөөлдөг, эрсдэлийг тооцдог талаар судалгаа, шинжилгээ хийж боловсруулан мэргэжлийн дүгнэлт гаргах.	Монгол Улсын хууль, журмын дагуу Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ байнгын ажиллагаатай байгаа эсэх, мөн. усны эрсдэлийг тооцдог эсэхийг нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлыг зорилго оршино, Аудитын багийн гишүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх,	Эрүүл ахуйн тухай хууль 4.1.Хүн амьг үндны болон ахуйн дараах нөхцөл, шаардлагыг хангасан усаар хангана: Усны тухай хууль 6.2.Усны хяналт-шинжилгээний улсын нэгдсэн сүлжээ байнгын ажиллагаатай дараах хэсгээс бүрдэнэ: 6.2.1.улсын хяналт-шинжилгээний сүлжээ; 6.2.2.сав газрын хяналт-шинжилгээний нэгж; 6.2.3.аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтын цэг.

4	Ундны усны чанарын нөхцөл байдал, ус ашиглалтын үйл ажиллагаанаас үзүүлэх өөрчлөлтийн байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах.	Усны чанарын нөхцөл байдал, ус ашиглалтын үйл ажиллагаанаас үзүүлэх өөрчлөлтөөс үүссэн усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ, татварын орчны нөхцөл байдал талаар судалж мэргэжлийн дүгнэлт гаргах.	Монгол Улсын хууль, журмын дагуу усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ, татварын орчны нөхцөл байдал талаар нягтлан шалгаж, шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлыг зорилго оршино.	ЗГ-ын 2013 оны 326-р тогтоол усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль 4.1.Ус, рашааны нөөцийг ашиглан хаягдал ус гаргаж, усны найрлага, чанарт нөлөөлж байгаа ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус бохирдуулсны төлбөр төлөгч байна.
5	Монгол Улсын ундны усны өнөөгийн нөхцөл, цаашид аюулгүй, баталгаат ундны усны хангагсан хүн амын эзлэх хувийн төлөв байдлын судалгаа хийж боловсруулж, , аудитын багт арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн дүнгэлт гаргах.	Тогтвортой хөгжлийн зорилгын ТХ3-6 буюу “тогтвортой усны нөөцийн менежментийг хөгжүүлэх” зорилтыг Монгол Улсын урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилт, өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, хууль эрх зүйн актуудын үйлчлэх хүрээ, уялдаа холбоотой байх зарчмууд.	Монгол Улсад ундны устай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, НҮБ-ын зорилгын ТХ3-6 буюу “тогтвортой усны нөөцийн менежментийг хөгжүүлэх”, зорилтыг судалж шинжээчийн дүгнэлт гаргахад энэхүү ажлыг зорилго оршино, Аудитын багийн гишүүдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх,	МУЗГУАХ-2020-2024, МУЗГУАХ-2024-2028, Төслийн баримт бичигт заасан хүрсэн байх түвшин Холбогдох хуулийн заалтууд НҮБ-ын ТХ3-ын 6.1 шалгуур үзүүлэлт, 6.2 шалгуур үзүүлэлт Алсын хараа болон Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан бодлогын заалт, хүрэх түвшин болон шалгуур үзүүлэлтүүд Хуульд заасан хэрэгжүүлэгч байгууллагын чиг үүрэг Судалгааны материалын үзүүлэлтүүд
6	TX3 6.1.1 буюу Баталгаат ундны ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүн амын эзлэх хувийг тооцож гаргах аргачлалыг холбогдох эрх зүйн актуудтай нийцүүлэн боловсруулсан эсэхэд шинжээчийн дүгнэлт гаргах, аудитын багт зөвлөгөө өгөх	Баталгаат ундны ус хангах, аюулгүй байдлыг үнэлэх тогтвортой тогтолцоо болон чиг үүрэг бий болсон байх шаардлага	Баталгаат ундны ус хангамжийн үйлчилгээ хүртэж байгаа хүн амын эзлэх хувийг тооцож гаргах аргачлалыг холбогдох эрх зүйн актуудтай нийцүүлэн боловсруулсан тогтолцоо Монгол Улсад бий болсон эсэхэд дүгнэлт гаргах	

Шинжээчийн ажлын тайлангууд нь хавсралтууд орохгүйгээр 30-аас багагүй 80-аас ихгүй хуудас /мөр хоорондын зайд “single” үсгийн хэмжээ Arial 12/ байх бөгөөд гэрээт ажлын гүйцэтгэлийн тайлан, хавсралтуудтай байна.

Дөрөв. ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ҮР ДҮН

Шинжээч нь ажлын даалгаварт тусгасан зорилгыг хэрэгжүүлэхдээ Төрийн аудитын стандарт, аudit хийх журам болон холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт, зарчим, шаардлагыг мөрдлөг болгож, Үндны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөөний хэрэгжилт НҮБ-ын ТХЗ-ын 6.1, 6.2-т заасан зорилгыг байгаа эсэхийг шалгаж, мэргэжлийн өндөр түвшинд дүгнэлт гарган үр дүнг тусгасан шинжээчийн тайланг бэлтгэнэ.

Шинжээчийн тайланд дүгнэлт гаргах явцад илэрсэн алдаа зөрчил, тэдгээрийн учир шалтгаан болон үр дагавар, эрсдэлд хийсэн дүн шинжилгээний үр дүнгээс гадна цаашид анхаарах асуудлын талаар бодлогын зөвлөмж, санал боловсруулж тусгана.

Шинжээч нь Үндэсний аудитын газартай гэрээ байгуулан ажиллах бөгөөд Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын аудитын багт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, шинжээчийн тайлан болон хавсралтаар гаргасан судалгаа, тооцоолол, бусад нотлох зүйлс, ажлын баримт материалыг цаасан болон цахим хэлбэрээр гэрээнд заасан хугацаанд аудитын багт хүлээлгэн өгнө.

Шинжээчээр шалгарсан **иргэн, хуулийн этгээд, баг** нь захиалагч Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор, аудитын менежер, аудитын багтай уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллана.

Үе шатны ажлын явцад бий болсон шийдвэрлэх боломжгүй асуудлыг тухай бүр захиалагч тал Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын “Үндны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын багт мэдэгдэж, хамтарч ажиллана.

Тав. ШИНЖЭЭЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Шинжээч ажлын хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах багийн бүрэлдэхүүнд хүн амыг аюулгүй, боломжийн үнэтэй үндны усаар хангаж байгаа байдалд шинжилгээ хийж, өнөөгийн нөхцөл, цаашдын төлөв байдлыг үнэлэх мэргэшсэн техникийн үйлчилгээ үзүүлж чадахуйц, тухайн салбарт ажиллаж байгаа болон ажлын дадлага, туршлагатай, дүгнэлт гаргах чиглэлээр эрх бүхий зөвшөөрөлтэй иргэн, баг, хуулийн этгээд, түншлэл /НҮБ-тай хамтарч ажилдаг бол давуу тал/ байна.

Монгол Улсын Үндсэн хуулиар дэмжигдсэн олон нийтийн эрх ашгийг дээдэлсэн, хууль тогтоомжид нийцсэн зарчмын шаардлагын дагуу ажил гүйцэтгэх этгээд нь ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ бүрэн илэрхийлсэн мэдэгдлийг гаргаж, албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлэх байдал үүсвэл эрх бүхий албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх бөгөөд Үндэсний аудитын газартай иж бүрэн түншлэлийн чиглэлээр нэгдмэл сонирхолтойгоор хамтран ажиллана.

Шинжээчийн ажлын хүрээнд мэргэшсэн, тухайн салбарт ажиллаж ирсэн ажлын дадлага, туршлагатай, зөвлөх үйлчилгээ үзүүлэх иргэн, баг, хуулийн этгээд /эсвэл хуулийн этгээдийн түншлэл/-тэй хамтран ажиллана.

Хуулийн этгээдийн хувьд:

- Ижил төрлийн ажил үйлчилгээг гүйцэтгэсэн, шинжилгээ, судалгаа хийж байсан ажлын дадлага, туршлагатай байх;
- Судалгааны арга зүй ашиглаж, үнэлгээ, дүгнэлт боловсруулах, багаар ажиллах, ёс зүйтэй, зөв хандлагатай байх;
- Хууль тогтоомжид заасан нөхцөл шаардлагын дагуу ашиг сонирхлын зөрчилгүй байх;
- Доор дурдсан мэргэжлийн боловсон хүчний нөөцтэй байх;

Гидрологич-Газрын доорх усны нөөцийн мэргэжилтэн

- Гидрологийн чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистр түүнээс дээш зэрэгтэй байх;
- 7 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан, газрын доорх усны чиглэлээр судалгаа хийсэн байх;
- Багаар ажиллах, ёс зүйтэй, зөв хандлагатай байх;

Гидрохимич-Усны чанарын мэргэжилтэн

- Усны хими, усны чанарын чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистр түүнээс дээш зэрэгтэй байх;
- 7 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан, усны чанарын чиглэлээр судалгаа хийсэн байх;
- Багаар ажиллах, ёс зүйтэй, зөв хандлагатай байх;

Экологич- усны

- Усны экологич чиглэлээр их, дээд сургууль төгссөн, магистр түүнээс дээш зэрэгтэй байх;
- 7 болон түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан, усны экологи чиглэлээр судалгаа хийсэн байх;
- Багаар ажиллах, ёс зүйтэй, зөв хандлагатай байх;

Хувь хүн, иргэний хувьд дээрх гүйцэтгэх ажлын зорилгуудыг хангах нарийн мэргэжлийн үнэлгээ хийх боломжтой, дээрх мэргэжлүүдээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан, судалгаа, шинжилгээ хийж байсан туршлагатай, усны шинжилгээ хийж, үр дүнг нэгтгэн гаргах чадвартай, бодлогын судалгаа хийж байсан, багаар ажиллах, ёс зүйтэй, зөв хандлагатай байх шаардлагыг хангасан байна.

Шинжээч нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажлын даалгаварт заасан ажлыг мэргэжлийн болон чанарын өндөр түвшинд хийж, шаардлагатай судалгаа, шинжилгээ, тооцоо бусад ажлыг хугацаанд нь үнэн зөв чанартай хийж гүйцэтгэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлж, дүгнэлт гаргах ажлыг гэрээгээр гүйцэтгэх шинжээч нь Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Үндны ус, ариун цэврийн байгууламжтай холбоотой хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүд, тэдгээрийн үр нөлөө” аудитын багийн бүрэлдэхүүнтэй хамтарч ажиллана.

Ажлын даалгаварт тусгасан ажлыг гүйцэтгэх шинжээч нь ажил эхлэхийн өмнө аудитын багтай урьдчилсан уулзалт, ярилцлага хийх, шаардлагатай асуудлаар нэмэлт тодруулга авч ажиллаж болно мөн үе шатны ажлын явцад

илэрсэн, хэрэгжүүлэх явцад үүссэн, шийдвэрлэх боломжгүй асуудал бий болсон тухай бүр захиалагч талын холбогдох албан тушаалтанд шууд мэдэгдэнэ.

Шинжээчийн бүрэлдэхүүн нь аудитын явцад олж авсан болон мэдсэн төрийн байгууллага, хувь хүний нууцад хамаарах мэдээллийн нууцлалыг хадгалах ба гэрээгээр тохиролцсон ажилд оролцож дүгнэлт гаргах үйлчилгээ үзүүлэхдээ мэргэжлийн болон ёс зүйн өндөр түвшинд шударгаар ажиллаж, төрийн аудитын байгууллагын ажилтны ёс зүйн дүрмийг нэгэн адил даган мөрдөж ажиллана.

Бүрдүүлэх материал:

- Шалгаруултад оролцохыг хүссэн өргөдөл, анкет, улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, боловсролын зэргийн диплом, мэргэшлийн гэрчилгээ, үнэмлэх, сертификатын хуулбар;
- Ажлын туршлагыг тодорхойлсон дэлгэрэнгүй намтар /багийн гишүүн тус бүрээр/;
- Бүтээлийн болон судалгааны жагсаалт;
- Техникийн санал /үүрэгт ажлыг хийх аргачлал, ажлын төлөвлөгөө/, санхүүгийн дэлгэрэнгүй санал /тусад нь дугтуйлсан байх/;

Зургаа. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Захиалагч, Гүйцэтгэгчийн хооронд байгуулах хоёр талт гэрээнд гүйцэтгэх ажлын цар хүрээ, тоо хэмжээнээс хамаарч гэрээний үнийн дүнг тусгана.

Төлбөрийг Монгол төгрөгөөр олгох бөгөөд ажлын хөлсөнд гүйцэтгэгч, шинжээчид холбогдох бүх зардал, татвар, хураамж багтсан байна.

Гүйцэтгэгчийн ажлын үр дүнд захиалагчаас өгсөн үнэлгээнд тулгуурлан санхүүжүүлэгч гэрээнд заасан төлбөрийг 100 хүртэл хувиар олгоно.

Гэрээт ажлын санхүүжилтийг гэрээнд заасан төлбөрийн хуваарийн дагуу олгоно.

ХЯНАСАН:

ГҮЙЦЭТГЭЛ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

д.ЭНХБОЛД

Х.БАЯРМАА

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР

Н.УРТНАСАН